

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭХ ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

REGARDING CHILDREN'S SCHOLARSHIP PROCEDURE



Е.Гүлнур

Дотоод хэргийн их сургуулийн сургалт, судалгааны 403-р анги шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521-р дамжааны сонсогч

Хураангуй: Гэр бүл нийгэмд маш олон үүрэг гүйцэтгэдэг. Гэрлэгсдийн нийгэмд гүйцэтгэх үүргийг тодруулах нь гэр бүлийн нийгмийн үүргийг биелүүлэх нэг үндэс юм. Гэр бүл нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хэр зэрэг биелүүлснээс манай нийгмийн сайн сайхан байдал ихээхэн хэмжээгээр шалтгаална. Манай орны тухайд авч үзвэл нүүдлийн мал аж ахуйгаас суурьшмал амьдралд шилжсэнээр гэр бүлийн нийгмийн үүрэг өөрчлөгдөж, гэр бүлийн амьдрал ахуйд олон талын өөрчлөлт гарлаа. Эмэгтэйчүүд нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдэж зарим тохиолдолд эрэгтэйчүүдээс илүү хөдөлмөрлөх болов. Энэ нь нөхрөө анхааран халамжлах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх боломж багасна гэсэн үг. Ингэснээр гэр бүлийн хэвийн амьдрал алдагдаж, амьдралын хүнд ачааг үүрч, бухимдалд орж цаашилбал гэмт хэрэгт ч орох явдал гарч байна. Эрэгтэйчүүдийн архидалт, танхайралт, хүүхэд тэнэмэл болох явдал ч үүнтэй холбоотой. Энэ бүхний үр дүнд гэр бүл салалт болж тэжээн, тэтгэх тэтгүүлэхтэй холбоотой харилцаа маш хүнд байдалд орж байна.

Түлхүүр үг: Тэжээгч, тэтгүүлэгч, тэжэн тэтгэх үүрэг, тэжээн тэтгүүлэх эрх үүсэх хугацаа, тэтгэлэг нөхөн гаргуулах, тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болох.

ҮНДСЭН ХЭСЭГ

Тэтгэлэг төлнө гэдэг нь юу гэсэн үг вэ?

Энэ нь хөдөлмөрийн чадваргүй, аль эсвэл насанд хүрээгүй буюу өөрийгөө тэжээх чадваргүй гэр бүлийн гишүүнээ тухайн гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай, насанд хүрсэн өөр нэгэн гишүүн нь гэрээ болон хуульд заасан үүрэг, шүүхийн шийдвэрийн дагуу мөнгөн хэлбэрээр эсвэл эд хөрөнгөөр тэтгэж буй хариу төлбөргүй, тодорхой хугацаанд үргэлжилсэн шинж чанар бүхий үйлдэл юм.

Саяны тодорхойлолтод дурдсанчлан, тэжээн тэтгэх үүрэг нь гэр бүлийн харилцаа үүсэж бий болсноос, талуудын хооронд байгуулсан гэрээнээс, мөн тэтгэлэг төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарснаас үүдэн бий болдог. Тэтгэлгийн хэлбэр, хэмжээ, хугацааны асуудлыг тэтгэлэг тогтоох гэрээ эсвэл хуульд заасны дагуу шүүхийн журмаар тогтоодог.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг эх нь насанд хүрээгүй, эсвэл насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй байдаг¹. Хэрэв эцэг эх нь салсан эсвэл тусдаа амьдардаг бол хоорондоо харилцан тохиролцож, гэрээ байгуулан хүүхдэдээ өгөх тэтгэлгийн хэмжээг тогтоож болно. Эсвэл мэдээж шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой. Хэрэв эхийнхээ асрамжид үлдсэн хүүхдийн эцгээс нь өгч буй тэтгэлгийг эх нь хүүхдийн хэрэгцээнд зарцуулаагүй тохиолдолд эцэг буюу тэтгэлэг төлөгчөөс зориулалтаар нь зарцуулуулахаар шүүхэд хандаж болох зохицуулалт Гэр бүлийн тухай хуульд тусгагдсан байдаг. Мөн тэтгэлэг төлөгч өөр хүүхэдтэй бөгөөд тэдгээр нь тэтгэлэг авагчаас бага орлоготой, тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадвараа алдсан, эсвэл тэтгэлэг авагч хүүхэд өөрөө хангалттай орлоготой болсон бол шүүхээс тэтгэлгийн хэмжээг багасгаж болно.

Хэрэв хүүхдийн эцэг эх нь эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, бусад шалтгаанаар хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад байгаа бол эцэг эхээс хүүхдэд олгох тэтгэлгийг асрах байгууллагын дансанд шилжүүлж, үүнээс тэтгэлгийн 50 хувийг хүүхдийн ахуйн хэрэгцээнд зарцуулж, үлдсэн хувийг хүүхдийн нэр дээрх хадгаламжийн дансанд шилжүүлнэ хэмээн хуулиар зохицуулсан байна².

¹ Гэр бүлийн тухай хууль, 1999 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30

² Гэр бүлийн тухай хууль, 1999 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30

Гэр бүлийн тухай хуульд хүүхдэд олгох тэтгэлгийн хэмжээг хуульчилж өгсөн. Тухайлбал, 11 хүртэлх насны хүүхдэд тогтоох тэтгэлгийн хэмжээ тухайн бүс нутгийн амжиргааны доод түвшингийн 50 хувьтай тэнцэхүйц, 11-16 нас, суралцаж байгаа бол 18 нас хүрсэн, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амжиргааны доод түвшингийн хэмжээгээр тогтооно гэсэн. Амжиргааны доод түвшин нь бүс нутаг, нийслэлд өөр өөр байх бөгөөд Улаанбаатар хотод 185,300₮ байхаар Засгийн газраас тогтоосон байдаг байна.

Тэтгэлэг тогтоох, төлөх журам:

Тэжээн тэтгэх гэрээний үндсэн дээр төлөгдөх тэтгэлгийг төлөх журмыг талууд тухайн гэрээгээр тодорхойлно. Тэжээн тэтгэх гэрээ байхгүй бол төлбөр тогтоох журам нь шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжаар тодорхойлогдоно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 128 дугаар зүйлд зааснаар гэрлэгчид харилцан тохиролцож тэжээн тэтгэх тухай гэрээг байгуулсан бөгөөд түүнийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд аль нэг талын хүсэлтээр гэрээг биелүүлэхтэй холбогдуулан шүүгч захирамж гаргана¹.

Хүснэгт 1. Тэжээн тэтгүүлэх эрх үүсэх хугацаа

Тэжээн тэтгүүлэх эрх бүхий этгээд нь тэтгэлэг авах эрх үүссэн цагаас, мөн түүнчлэн өмнө нь байгуулсан тэжээн тэтгэх гэрээний дагуу тэтгэлэг аваагүй бол тухайн гэрээний хугацаа дууссан эсэхээс үл шалтгаалан тэтгэлэх тогтоолгох тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй.

Тэтгэлэгийн тухай асуудал нь шүүхэд хандан нэхэмжлэл гаргасан цагаас эхлэн хэлэлцэгдэнэ.

Тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол тэтгүүлэгчид тэтгэлэг нөхөн гаргуулах эрх үүсч болно.

Хүснэгт 2. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №8



Судалгаанаас үзэхэд: Тэтгэлэг тогтоолгосон хүүхдийн тоо сүүлийн 3 жилд эрс нэмэгдсэн нь Монгол Улсын иргэд эрх зүйн мэдлэгтэй болсонтой шууд холбоотой гэж үзэж байна.

Тэтгэлэгийг хуулийн хугацаандаа төлөөгүйгээс болж үүсэх хариуцлага:


Тэжээн тэтгэх тухай гэрээг сайн дураар биелүүлэхгүй байгаа тохиолдолд тэдний хэн нэгний хүсэлтээр шүүгч захирамж гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлнэ. Тэжээн тэтгэх тухай гэрээний дагуу тогтоох тэтгэлгийн хэмжээ нь тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний хэмжээнээс багагүй байна. Тэжээн тэтгэх тухай гэрээний дагуу тогтоох тэтгэлгийн хэлбэрийн хувьд мөнгөн болон эд хөрөнгөөр, хугацаа нь сар, улирал, хагас жил, жилд нэг удаа байж болно. Тэтгэлгийг эд хөрөнгөөр олгохоор талууд харилцан тохиролцсон бол эд хөрөнгийг орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлнэ.

Тэжээн тэтгүүлэгчид онцгой нөхцөл байдал тохиолдсон /хүндээр өвчилсөн, тахир дутуу болсон, эмчлүүлсэн, сургуульд орсон гэх мэт/ үед түүнд нэмэлт тэтгэлэг гаргуулах, эсхүл гарсан зардлыг хариуцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол шүүх тэжээн тэтгүүлэгч, бусад иргэн, холбогдох байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн төлүүлж болно. Тэтгэлэг нөхөн төлүүлэхэд тэтгэлэг төлөгч хөдөлмөр эрхлээгүй буюу цалин хөлс, бусад орлогын хэмжээг тогтоох боломжгүй бол тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтална. Тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд тухайн хугацааны

тэтгэлгийн хэсгийг буюу бүхэлд нь нөхөн төлүүлэхээс шүүх чөлөөлж болно¹.

Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлнө. Алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй тэтгэлгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна².

Хүснэгт 3. Тэтгэлэгийг нөхөн гаргуулах үндэслэл журам



Зөрчлийн тухай хуулийн 6.20-р зүйлийн 6-д “Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр тогтоосон сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага


¹ Ч.Дондог. Гэр бүлийн эрх зүй. УБ., 2015 он. 22-23 дахь тал.

² Гэр бүлийн тухай хууль, 1999 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30

хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан¹.

Энэхүү торгох шийтгэл нь иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр өөрийн буруутай үйлдлээ ухамсарлах боломж олгодог. Нийслэлийн хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхээс жилдээ тэтгэлэг албадан төлүүлэх 600-800 хүсэлт ирдэг байна. Ерөнхийдөө 4500-5000 хүүхдийн тэтгэлгийн баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа аж. Энэ бол зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ирсэн хүсэлтийн тоо. Нэг шийдвэр гүйцэтгэгч дээр хүүхдийн тэтгэмжийн 200-гаад материал ногддог байна. Өмнө нь Эрүүгийн хуулийн 120-р зүйлд хүүхдийн тэтгэмжээс зайлсхийсэн бол эрүүгийн ял шийтгэл оноохоор тусад нь хуульчилсан байжээ. Одоо мөрдөгдөж буй Эрүүгийн хуулинд хүүхдийн тэтгэлэг төлөөгүйтэй холбоотой хариуцлагын ямар нэгэн заалт алга.

Хүснэгт 4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан Хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулалт




Судалгаанаас үзэхэд: Шүүхийн шийдвэр гарснаас хойш сайн дурын үндсэн дээр тэтгэлэг төлөөгүй тохиолдолд тэтгэлгийг нөхөн төлүүлэх асуудал яригдах бөгөөд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх захирамж гарснаас хойш тэтгэлэг төлөлт хийгдээгүй болон тэтгэлэг нь тасалдсан тохиолдолд төлөгдөөгүй тэтгэлэг дээр нэмж хугацаа хэтэрсэн алдангийн тооцуулан нөхөн төлүүлэхээр дахин шүүхэд


¹ Зөрчлийн тухай хууль, 2017 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24

хандсанаар энэ эрхээ хэрэгжүүлэх боломжтой болно. Мөн шүүхийн шийдвэрийг сайн дурын үндсэн дээр биелүүлэхгүй, шийдвэр гүйцэтгэх байгууллага тэтгэлгийг төлүүлэхэд онцгой анхаарч ажиллаагүйн улмаас тэтгэлэг авагч нь 18 насанд хүрсэн тохиолдолд хэргийн материалыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хааж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй болно. Учир нь тэтгэлэг авагч 18 насанд хүрч эрх зүйн чадвар, чадамжтай болсон хэдий ч хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр биелэгдээгүй байгаа учир хөөн хэлэлцэх хугацаа үүнд хамааралгүй болно.

Хүснэгт 5. Хүүхдийн тэтгэлэг төлөх үүрэг дуусгавар болох



Хүснэгт 6. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан Хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулалт



Судалгаанаас үзэхэд: Хүүхдийн тэтгэлгийн төлбөрийг барагдуулсан, бүрэн дуусгавар болгосон үзүүлэлт нь маш муу байгаа нь Монгол Улсад хүүхдийн тэтгэлэг барагдуулах ажиллагааны хэр зэрэг муу чанартай явагдаж байгааг үзүүлж байна.

ДҮГНЭЛТ

Гадаадын ихэнх оронд гэрлэлтийн гэрээг байгуулж хэвшсэн ба энэхүү гэрээгээр гэр бүл цуцалсан тохиолдолд эд хөрөнгийн маргааныг хэрхэн шийдвэрлэх, тухайлан хүүхдийн тэтгэлэг төлөх талаар тусган талууд баталгаажуулсан байдаг тул тухайн харилцаанд маргаан гарах нь бага байдаг байна. Харин Монгол Улсын Иргэний хуулийн 32 дугаар зүйлд гэрлэгчид зөвхөн хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулахаар заасан тул хүүхдийн тэжээн тэтгэх эрхийн тухай асуудлыг орхигдуулсан байна. Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн практикт гэрлэлтийн гэрээ хийж буй асуудал учир дутагдалтай бага байна. Зүй нь гэрлэлтийн гэрээнд зөвхөн хөрөнгийн асуудал бус үр хүүхдээ тэжээн тэтгэх асуудлыг тусгасан байдлаар хуульчилж, гэр бүл батлуулахад зайлшгүй гэрээг харгалзан үздэг байх нь зүйтэй гэж үзлээ. Залуучуудад гэр бүл болохын өмнөх эрх зүй, эдийн засгийн мэдлэг, боловсрол дутмаг тул гэр бүл салалт гэх асуудал манай улсад түгээмэл асуудлуудын нэг болсон. Тэтгэлэг гэдэг бол хүүхдийн тухайн үеийн хэрэгцээнд зарцуулагдана гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй. Түүнээс биш ээжид нь өгөөд байгаа юм биш. Тухайн ээж ч гэсэн өөртөө хэрэглэх гээд нэхээд байгаа асуудал биш.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж

1. Гэр бүлийн тухай хууль, 1999 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30
2. Зөрчлийн тухай хууль, 2017 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №8

Хоёр. Ном, сурах бичиг

1. Ч.Дондог. Гэр бүлийн эрх зүй. УБ., 2015 он
2. А.Батбаатар. Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй. Улаанбаатар хот., 2021 он

Гурав. Гадаад эх сурвалж

1. Л.М.Пчельницева Семейное право России учебник для вузов. М., 2001 год

2. "Семейный кодекс Российской Федерации" Статья 75. Контакты ребенка с родителем, родительские права которого ограничены судом

Дөрөв. Цахим эх сурвалж

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <https://www.1212.mn>